



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 1/289

Ховд


「 Эх үүсвэрийн зохицуулалт хийж 2021 оны
татварын буцаан олголтыг олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны "Аймгийн 2022 оны төсөв батлах тухай" 05/07 дугаар тогтоолын 12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Татварын хэлтсээс татвар төлөгчдийн 2021 оны татварын тайлангаар хийсэн тооцоогоор буцаан олгох 1190 хүнтэй холбоотой 728,160,628 төгрөг 70 мөнгө (долоон зуун хорин найман сая нэг зуун жаран мянга зургаан зуун хорин найман төгрөг далан мөнгө)-ний эх үүсвэрийг зохицуулалт хийж олгосугай.

2. Татварын тайлангийн тооцоогоор буцаан олгох 728,160,628 төгрөг 70 мөнгийг аймгийн Засаг даргын барьцаа данснаас урьдчилан санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д зөвшөөрсүгэй.

3. Татварын тайлангийн тооцоогоор буцаан олголтыг санхүүжүүлсэн 728,160,628 төгрөг 70 мөнгийг төсвийн орлогын данснаас тооцож төвлөрүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д үүрэг болгосугай.



Б.ДҮГЭРЖАВ

8200 01 1468